



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/661

Булган сум

Ц.Баттулгад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний хүчит 32 бөхийн барилдаан зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Парис 2024” зуны Паралимпийн наадамд бөөрөнцөг түлхэлтээр амжилттай оролцон мөнгөн медаль хүртсэн тамирчин Цэгмидийн Баттулгад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний хүчит 32 бөхийн барилдаан шагнал болон хэвлэлийн зардалд 7,857,700 (долоон сая найман зуун тавин долоон мянга долоон зуу) төгрөгийн дэмжлэг үзүүллүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
10 дугаар сарын 03-ны/ний өдрийн А/661 дугаар  
захирамжийн хавсралт

“Парис 2024” зуны Паралимпийн наадамд бөөрөнцөг түлхэлтээр амжилттай оролцон  
мөнгөн медаль хүртсэн тамирчин Цэгмидийн Баттулгад хүндэтгэл үзүүлэх арга  
хэмжээний төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	1	2	3	4
<i>Хүчит 32 бөхийн бай шагнал</i>				
1	5 давж түрүүлсэн	1	2,000,000	2,000,000
2	4 давж түрүүлсэн	1	1,000,000	1,000,000
3	3 давж шөвгийн 4-т үлдсэн	2	500,000	1,000,000
4	2 давсан	4	150,000	600,000
5	1 давсан	8	100,000	800,000
<b>Нийт</b>				<b>5,400,000</b>
<i>Бусад зардал</i>				
6	Бяслаг	2ш	80,000	160,000
7	Ааруул	4кг	28,250	113,000
8	Өрөм	1ш	25,000	25,000
9	Хадаг	4ш	8,000	32,000
10	Боорцог	10кг	9,000	90,000
11	Эм боох материал	1	80,000	80,000
<b>Нийт</b>				<b>500,000</b>
<i>Хэвлэл</i>				
12	Цэнгэлдэх төв асар /хөмсөг хэвлэл/	18,2x85	185,640	185,640
13	Эх бэлтгэл	5x10,000	50,000	50,000
14	Анонс 37,65x085 / төв асар хоёр тал	2ш	384,030	768,060
15	Хас банк, хаан банкны самбар 6x3	4ш	864,000	864,000
16	Бөгж /хулдаасан хэвлэл өлгөх/	300ш	300	90,000
<b>Нийт</b>				<b>1,957,700</b>
<b>Нийт дүн</b>				<b>7,857,700</b>